



ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ХИЙХ НЬ БИЗНЕСТ ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

Сүүлийн 10 жилийн турш “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд”-д “Хүний эрхийн магадлан шинжилгээ”-г хийх үүрэг хариуцлагыг тусгаснаас хойш дэлхийн нэр хүндтэй, нөлөө бүхий бизнесийн байгууллагууд хүний эрхийн магадлан шинжилгээг тогтмол хийж, үр дүнгээ олон нийтэд тайлагнасаар иржээ. Эдүгээ дэлхийн алдартай брендүүд болох Adidas, Nike, Apple, Marks & Spencer, Nestle, болон Unilever гэх мэт төрөл бүрийн үйл ажиллагаа эрхэлдэг томоохон бизнесүүд өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанараас гадна, хүний эрхийг хүндэтгэх үүргийн гүйцэтгэлээрээ бусад компаниудтай өрсөлддөг болсон билээ. Гэвч сайн дурын шинжтэй хүний эрхийг хүндэтгэх бизнесийн байгууллагын үүргийн хэрэгжилт төдийлөн хангалттай биш байгаагаас одоогоор дэлхийн 13 гаруй улс (тэр дундаа хөгжсөн орнууд болох Их Британи, АНУ, Франц, Герман, Канад, Австрали, Нидерланд болон Бельги зэрэг улсууд багтана) хүний эрхийн магадлан шинжилгээг заавал хийх бизнесийн байгууллагын үүргийг тусгасан хууль тогтоомжийг батлаад байна.

ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ХИЙСНЭЭР БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БИЙ БОЛОХ ЭЕРЭГ ҮР ДҮН:

Бизнесийн байгууллагууд нь хүний эрхийн магадлан шинжилгээг үр дүнтэй, тогтмол хийж, өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр дараах эерэг үр дүнг бий болгох боломжтой. Үүнд:

1. Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын менежмент сайжирна.
2. Хүний эрх, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, жендерийн эрх тэгш байдал, авилга хээл хахуулиас ангид орчинг бий болгох зэргээр нийгэмд үнэ цэнэ авчрах эерэг нөлөөллүүдийг бий болгож, тогтвортой, хариуцлагатай компанийн засаглал бэхжинэ.
3. Ажлын ая таатай орчин бий болж, ажилтнууд эерэг хандлагаар ажилдаа хандаж, тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөц бүрдэнэ.
4. Бизнесийн байгууллагын нийгэм дэх нэр хүнд өсч, үр дүнд нь компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр хүнд, борлуулалт нэмэгдэнэ.

БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ХҮНИЙ ЭРХ ЯАГААД ХАМААРЛТАЙ ВЭ?



Хэдийгээр бизнесийн байгууллагууд нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлж, баялаг бүтээж, улс орныг хөгжин дэвшихэд үнэтэй хувь нэмэр оруулдаг ч, үйл ажиллагаагаараа дамжуулан хүний эрх, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх тохиолдлууд бий. 1960-аад оноос эхлэн дэлхий даяар бизнесийн байгууллагуудын хүний эрх, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөлд олон нийт онцгой анхаарал хандуулах болсон. НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл 2011 онд “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд”-ыг баталж, бизнесийн байгууллагуудыг хүний эрхийг хүндэтгэн ажиллахыг уриалж эхэлсэн билээ.

Human Rights Due Diligence (HRDD)

БУЮУ ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

2011 онд НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс баталсан “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд”-ын хоёр дахь тулгуурын зарчмууд нь бизнесийн байгууллагын хүний эрхийг хүндэтгэх хариуцлагыг илтгэдэг. Бизнесийн байгууллагуудын зайлшгүй биелүүлбэл зохих чухал нэг үүрэг бол хүний эрхийн магадлан шинжилгээг үр дүнтэй, тогтмол хийж гүйцэтгэх билээ.

ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ гэдэг нь бизнесийн байгууллага үйл ажиллагаагаараа дамжуулан хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэх, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг илрүүлэх, бууруулах, арилгах мөн зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор үйл ажиллагаандаа цогц магадлан шинжилгээ хийхийг хэлнэ.

ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ХИЙХ ҮЕ ШАТ, ХИЙГДЭХ АЖЛУУД

Бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөг тодорхойлох, үнэлэх

- Тухайн салбарт нийтлэг тохиолддог хүний эрхийн сөрөг нөлөөлөл, зөрчлийг судлах, ерөнхий ойлголттой болох;
- Тухайн бизнесийн салбар, үйл ажиллагаанаас шалтгаалан эрх нь зөрчигдөх өндөр эрсдэлтэй субъектуудыг тодорхойлох (гэрээт ажилтнууд, эмэгтэй ажилтнууд, хүүхдүүд, орон нутгийн иргэд гэх мэт);
- Тодорхойлсон субъектуудтай уулзаж, мэдээлэл цуглуулах;
- Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бизнесийн үйл ажиллагаанаас тухайн субъектүүдийн эрхэд шууд болон шууд бусаар сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлох;
- Тодорхойлсон бодит зөрчил болон учирч болзошгүй зөрчлийг хөнгөн, дунд, хүнд хэлбэрээр нь үнэлэх, ангилах.

УДИРДАХ ЗАРЧИМ 18



Тодорхойлох, үнэлэх

1

Тодорхойлсон хүний эрхийн сөрөг нөлөөлөл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгахтай холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх

- Учирч болзошгүй болон бодитоор тулгарсан хүний эрхийн сөрөг нөлөөлөл, зөрчлийг тодорхойлж, ангилсны дараа тухайн сөрөг нөлөөлөл, зөрчлийн хөнгөн, дунд, хүнд хэлбэрт тохируулан авах арга хэмжээг төлөвлөх;
- Сөрөг нөлөөлөл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах, арилгахын тулд нэн даруй авах арга хэмжээг тодорхойлсон үйл ажиллагааны цогц төлөвлөгөөг боловсруулах;
- Төлөвлөгөөг боловсруулахдаа аль болох үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс хариуцах албан тушаалтан, хэрэгжүүлэх хугацаа, гарах үр дүнг бодитой тодорхойлох;
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хамтран ажиллаж болох төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллага болон бусад оролцогчдыг оролцуулах, хамтран ажиллах.

УДИРДАХ ЗАРЧИМ 19

Төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх

2

Үйл ажиллагааны хэрэгжилтэд тогтмол хяналт тавих

- Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд тодорхой стандарт, шалгуур тавьж, үр дүнг тогтмол үнэлэх;
- Авах арга хэмжээг хэрэгжүүлэх, албан тушаалтан, мэргэжилтнийг чадваржуулах;
- Үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө хөндлөнгийн хараат бус мэргэжлийн байгууллагыг оролцуулах;
- Хэрэгжүүлж буй арга хэмжээ тодорхой үр дүнд хүрээгүй тохиолдолд илүү оновчтой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

УДИРДАХ ЗАРЧИМ 20

Гүйцэтгэлийг хянах

3

Нээлттэй, ил тод мэдээлэх

- Хүний эрхийн магадлан шинжилгээгээр эерэг үр дүнг бий болгохын тулд хүний эрхийн магадлан шинжилгээ хийх үйл явцын мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж, тогтмол мэдээллээр хангах;
- Үйл ажиллагаанд оролцогч талуудад, ялангуяа хүний эрхэд нь сөргөөр нөлөөлж буй талуудыг хүний эрхийн магадлан шинжилгээ хийх үйл ажиллагаандаа татан оролцуулах;
- Хүний эрхийн магадлан шинжилгээний үйл явц, үр дүнгийн мэдээллийг хүлээн авсан оролцогч талуудтай тогтвортой харилцааг бий болгож, тэдний санал бодлыг сонсож, үйл ажиллагаандаа тусгах.

УДИРДАХ ЗАРЧИМ 21

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ
ХАМРУУЛАХ

Хүний эрхийн магадлан шинжилгээг хийх явц, үр дүнг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх